

Бодлого, дүн шинжилгээний баг

ИЛ ЗАДГАЙ ЗОГСООЛ ТАЛБАЙД ОРОХ ГАРАХАД ТӨЛБӨР, ХУРААМЖ АВАХ АСУУДАЛ

Оршил

Хүний Эрхийн Үндэсний Комиссын 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.3-д заасны дагуу Ил задгай зогсоол, талбайд орох гарахад төлбөр хураамж авч буй нь хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх асуудлаар дүн шинжилгээ хийснээ илтгэж байна.

Мэдээлэл цуглуулах ажиллагааг 2009 оны 07 дугаар сарын 27-нээс 08 дугаар сарын 14-ны дотор явуулсан бөгөөд энэхүү тайлангийн үндсэн мэдээллийг Нийслэлийн Авто замын газар, Нийслэлийн газрын алба, Улсын татварын ерөнхий газар болон Бишрэлт зочид буудал, Барс худалдааны төв, Нарантуул худалдааны төв зэрэг байгууллагуудаас авсан болно.

НЭГ. ЕРӨНХИЙ АГУУЛГА

1999 онд болсон Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт дээр НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Н.Кофи Аннан Бизнесийн үйл ажиллагаа нь сая сая хүнийг ажлын байраар хангадаг ч өдөр тутмын олон төрлийн үйл ажиллагаа нь хүний эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүйг тэмдэгдэж, бизнесийн хүрээнийхэнд хандаж Даяаршлын тунхагийг дэвшүүлэн гаргасан. Энэхүү тунхаг ёсоор аливаа бизнесийн байгууллага пүүс компани нь үйл ажиллагаагаараа дамжуулан олон улсын хэмжээнд тунхагласан хүний эрхийг хүндэтгэн сахих, зөрчихгүй байх ёстой.

Сүүлийн жилүүдэд бизнесийн байгууллагууд олноор байгуулагдах болж олон хүнийг ажлын байраар хангаж буй ч тэдний ашгийн төлөөх үйл ажиллагаа нь хүний эрхийг зөрчих, үйлчлүүлэгчээ үл хүндэтгэх зэрэг зохисгүй үйлдэл гаргаж байна.

Үүний нэг илрэл нь бизнесийн үйл ажиллагааг эрхэлж буй зарим аж ахуйн нэгж байгууллагууд тэр дундаа худалдаа, үйлчилгээний байгууллагууд үйлчлүүлэгчдээсээ автомашинаа зогсоолд нь байрлуулахад төлбөр авах явдал элбэг болж байна.

Худалдаа, үйлчилгээний байгууллагууд нь өөрийн нутаг дэвсгэр дэх зогсоолын талбайгаас төлбөр, хураамж авах нь хууль зүйн үндэслэлтэй эсэх, энэ асуудал нь ямар эрх зүйн зохицуулалт, бодлогоор зохицуулагдаж байгаа зэрэгт “Бодлогын дүн шинжилгээ” хийх аргаар уг ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Ил задгай зогсоолоос төлбөр хураамж авах асуудал үндсэн 2 хэлбэрээр явагдаж байна. “Аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшил газраас ил задгай зогсоолын төлбөр” авч байгаа нөгөө нь “нийтийн эзэмшил болон хувийн эзэмшил газраас хувь хүн, байгууллага зориулалтын зогсоол ажиллуулах ажил үйлчилгээ эрхлэх журмаар” төлбөр авч байна. Үүнээс бид аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшил газраас төлбөр авч буй, ялангуяа худалдаа, үйлчилгээний зориулалтаар баригдсан объект дахь зогсоолын талбайгаас төлбөр авч буй асуудлыг судаллаа.

Ил задгай зогсоолоос төлбөр авах асуудал дараах хууль тогтоомжоор зохицуулагдаж байна. Үүнд:

Иргэний хууль
Авто замын тухай хууль
Газрын тухай хууль
Татварын ерөнхий хууль
Газрын төлбөрийн тухай хууль
Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
Барилгын тухай хууль
Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль
Монгол Улсын засгийн 2002 оны 177 дугаар тогтоол
Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамж

МУ ын Барилгын тухай хуульд зааснаар аливаа барилга байгууламж нь зураг төсөл, норм стандартын дагуу баригдах ёстой. Энэхүү барилгын норм стандартын дагуу аливаа барилга байгууламж нь дагуу өөрийн гэсэн зогсоолын талбайтай байх ёстой юм байна. Энэ талаар Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамнаас гаргасан “Барилгын норм ба дүрэм”-ийн 30.01.04-д аливаа барилга байгууламж дахь тээврийн хэрэгслийн зогсоолын нормативыг тогтоож өгсөн байдаг. Энэхүү норм-д үйлчилгээний байгууллагууд үйлчлүүлэгчийнхээ эрх ашиг, тав тух, тухайн барилгын зориулалт, үйл ажиллагааны онцлогоос хамаарч тодорхой стандарт бүхий зогсоолын талбайтай байхаар зохицуулсан байна. Тухайлбал Худалдааны төв, их дэлгүүрийн хувьд гэхэд үйлчлүүлэгчийн тоо, талбайгаас хамаарч 100 ам/м талбай бүрт 7 машины зогсоолтой байх, 50 худалдах цэгтэй захын хувьд 25 зогсоолын талбайтай байх ёстой байна. Иймд энэхүү зогсоолын газар нь барилгын стандарт нормын дагуу тухайн барилгад байх ёстой барилгын орчны тохижилтын нэг бүрэлдэхүүн хэсэг юм байна.

Нөгөө талаар иргэний хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 –г ... түр зуурын хэрэгцээ хангах зорилгоор бус байнгын зориулалттай, газартай салшгүй бэхлэгдсэн байшин, барилга, байгууламж болон бусад зүйл нь газрын үндсэн бүрдэл хэсэг байна гэж зааснаар дээрхи үйлчилгээний зориулалтаар баригдсан барилга байгууламжийн бүрдэл хэсэг нь зогсоолын талбайн газар гэж үзэж болохоор байна.

Иймд барилгын норм, нормативын дагуу үйлчилгээний зориулалтаар баригдсан зах, буудал, дэлгүүр, эмнэлэг, нисэх буудал, вокзал зэрэг байгууллагууд тухайн барилгын салшгүй нэг хэсэг болох үйлчлүүлэгчийн хэрэгцээнд зориулагдсан зогсоолын талбайгаасаа төлбөр авах нь үйлчлүүлэгчийн эрх ашгийг хүндэтгэхгүй байгааг харуулж байна.

3.1.5. “барилгын норм, нормативын баримт бичиг” гэж барилга байгууламжид мөрдөх нийтлэг шаардлага зарчмыг агуулсан барилгын норм, дүрэм, стандарт, цомог, заавар, журмыг хэлнэ.

22.1. Барилгын норм, нормативын баримт бичгийг заавал мөрдөнө.

3.1.11. “барилгын орчны тохижилт” гэж тухайн барилгад олгосон газарт барилгажилт, төлөвлөлтийн нормын дагуу төлөвлөсөн мод, бут, сөөг зэрэг ногоон байгууламж, зам, тээврийн хэрэгслийн зогсоол, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, гэрэлт үүлгийг хэлнэ.

Үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулийн 5 дугаар зүйлийн 1-т Хэрэглэгч эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн нөхцөл, барилгын болон эрүүл ахуй, ариун цэврийн норм, фармакопей /эмийн чанар, стандарт/, жор, түүнчлэн хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлсон зохих чанар, тоо хэмжээ, аюулгүйн шаардлагыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах эрхтэй гэж заасан байна. Үүнээс үзвэл, үйлчлүүлэгч аливаа үйлчилгээг авахдаа барилгын норм шаардлагын дагуу баригдсан зогсоолын талбайгаар үйлчлүүлэх эрхтэй гэж үзэж байна.

Гэвч Монгол улсын Авто замын хууль түүнд нийцүүлэн гаргасан Нийслэлийн засаг даргын 2004 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 49 дүгээр захирамжаар аж ахуйн нэгж байгууллага өөрийн нутаг дэвсгэр дэх дотоодын замаас төлбөр авах эрх зүйн үндсийг бий болгосон байна.

Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д”... Аж ахуйн дотоодын замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах журам, төлбөрийн хэмжээ, аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.”, мөн Монгол улсын Засгийн газрын 2002 оны 177 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн Нийслэлийн засаг даргын 2004 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 49 дүгээр захирамжаар “ Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах журам –ыг батлан гаргасан байна.

Засгийн газрын 2002 оны 177 дүгээр тогтоолын 2 –т ...” аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам, замын байгууламж, талбайгаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах цэгийн байрлал, төлбөрийн хэмжээг тогтоохдоо авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний дагуу баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймаг,нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журмаас:

Авто замын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т зааснаар " Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам" гэж байгууллагын нутаг дэвсгэр дэх олон улсын болон орон нутгийн чанартай авто замаас бусад замыг хамааруулсан.

Авто замын тухай хуулиас:

Энэхүү хууль тогтоомжийг үндэслэн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа Нарантуул, Барс, Хар хорин, Тэнгис кино театр, Вокзал, Хүчит шонхор зэрэг нийт 11 худалдаа үйлчилгээний байгууллагууд үйлчлүүлэгчдээсээ авто машинтай нэвтэрсний төлөө төлбөр авч байна.

Аж ахуйн дотоодын замаас төлбөр авч буй байгууллагуудын тоог 2004-оны 3 сард Нийслэлийн Авто замын газраас гаргаснаас өөр нэгдсэн тоо бүртгэл хийгдээгүй байна.

Энэхүү төлбөр авах үндэслэл болсон Нийслэлийн засаг даргын захирамж нь улсын нэгдсэн бүртгэлийн сангийн 2004 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 2424 дугаарт бүртгэгдсэн хүчин төгөлдөр эрх зүйн акт байна.

Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамж нь тухайн аж ахуйн нэгж байгууллага иргэдээс зогсоолын төлбөр авах хууль зүйн үндэслэл болохын зэрэгцээ тухайн аж ахуйн нэгж байгууллагад газрын төлбөрөө төлөх санхүүгийн таатай нөхцлийг бүрдүүлсээр байна.

Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамжаар Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж буй тээрийн хэрэгслээс өмчийн хэлбэрийг үл харгалзан төлбөр авах журмыг тогтоож, уг төлбөрийн орлогын 40 хувийг Нийслэлийн замын санд төвлөрүүлэхээр заасан байна. Харин энэхүү төлбөрийн орлого тухайн аж ахуйн нэгж байгууллагын халаасанд буюу газрын төлбөрөө төлөх эх үүсвэр нь болдог байна.

Зочид буудлын авто машины зогсоолын талбайн газар манай компанийн эзэмшлийн газар тул зогсоол дээр машинаа байрлуулж буйн төлөө бид төлбөр авдаг. Бид энэ мөнгөөр буцаагаад газрын төлбөрөө төлдөг.

Бишрэлт зочид буудлын ерөнхий нягтлантай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас:

Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар, Татварын газар, Зам тээврийн газар /одоогийн Авто замын газар/ -т даалгасан байна. Гэвч энэхүү захирамжийн биелэлт хангалтгүй захирамжийн дагуу нэг ч төгрөг Нийслэлийн авто замын санд төвлөрөөгүй байна.

Нийслэлийн авто замын газраас эдгээр байгууллагуудын удирдлагуудад удаа дараа шаардлага тавьж албан бичиг явуулж, биечлэн уулзаж байсан ч Нийслэлийн Засаг даргын

49 дүгээр захирамжийн дагуу энэхүү төлбөрийн тодорхой хувийг Нийслэлийн авто замын санд өгөх сонирхолгүй байна.

Дээрхи байгууллагуудаас Нийслэлийн авто замын санд орлогын зохих хувийг төлөхгүй байгаа шалтгааныг тодруулахад “газрын төлбөрийг төлж байгаа”, “тухайн авто зам, газарт хөрөнгө оруулалт хийсэн”, “аж ахуйн үйл ажиллагаа явуулсны орлого татварт төлж байгаа” зэргээр тайлбарлаж байна.

Тус компани нь худалдааны төвийнхөө авто зогсоолд өөрийн 100 хувийн хөрөнгөөр зам талбай зассан бөгөөд аж ахуйн үйл ажиллагаа явуулсны татварыг зохих хуулийн дагуу өгдөг. Дээрх дурдсан аж ахуйн үйл ажиллагаа явуулсны татвар төсөвт орж тодорхой хувь нь Нийслэлийн авто замын засварт орж байгаа болов уу гэж бодож байна. Иймд уг саналыг хүлээн авах боломжгүй юм.

Нарантуул трейд ХХК-ны 2/17 тоот албан бичгээс:

Уг захирамжийн 5 дүгээр зүйлийн 5.1-т “...Аж ахуйн нэгж байгууллага нь төлбөрийн орлогыг нуун дарагдуулсан, тасалбар хуурамчаар үйлдсэн, тасалбаргүй мөнгө хураасан нь илэрвэл хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэсний дагуу төлбөрөө замын санд төлөөгүй байгууллагуудад хариуцлага хүлээлгэж арга хэмжээ авсан асуудал байхгүй байна.¹

Эдгээр худалдаа, үйлчилгээний байгууллагууд ийнхүү төлбөр авахдаа төлбөрийн хэмжээг өөрсдийн дур зоргоор тогтоон авч байна.

Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамжинд зааснаар худалдаа, соёл үйлчилгээний төвүүд хөнгөн тэрэгнээс 100 төгрөг, том оврын автобуснаас 200 төгрөг авч байхаар тогтоосон ч бодит амьдрал ихэнх худалдаа, үйлчилгээний байгууллагууд өөрсдөө дур мэдэн үнэ тогтоож 200-500 төгрөгийг авто машин бүхий иргэдээс авч байна.

Чингис хаан нисэх буудлын зам тэдний хөрөнгөөр хийгдээгүй Нийслэлийн хөрөнгөөр хийгдсэн. Нийслэлийн хөрөнгөөр хийгдсэн зам гүүрийг манай байгууллага засах ёстой байдаг. Гэтэл манай ажилтнуудыг замаа засахаар ороход хүртэл төлбөр нэхсэн тохиолдол гарсан.

Нийслэлийн авто замын газрын авто замын ашиглалтын инженер Баянмөнхтэй хийсэн ярилцлагаас:

Хэрвээ эдгээр байгууллагууд авто зогсоолын төлбөртэй үйлчилгээ эрхэлж байгаа бол тухайн машины бүрэн бүтэн байдал харуул хамгаалалтыг бүрэн хариуцах ёстой. Гэтэл иргэд тухайлбал Нарантуул захаар үйлчлүүлэхээр орохдоо тасалбар авч орохоос гадна

¹ Нийслэлийн авто замын газрын санхүү, зураг төслийн газрын даргатай хийсэн ярилцлагаас

авто машины зогсоолын төлбөр, машинахаа бүрэн бүтэн байдлыг харуулсаны төлбөр зэрэг давхар давхар төлбөр хураамжийг төлж байна.

Тухайн байгууллагаар үйлчлүүлэхээр орж байхад төлбөр хураамж авах нь утгагүй юм. Тэгсэн хэрнээ машины аюулгүй байдлыг хангаж чаддаггүй. Миний машины толь алдагдаж ч байсан. Мөнгөө өгсөн хэрнээ ингэж болохгүй ш дээ. Мөн хэрвээ үнэхээр зам гүүр нь мөнгө өгсөн гээд засардаг бол мөнгө өгч бөлж байна.

Да хүрээ захын үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагаас

Худалдаа, үйлчилгээний байгууллагууд зогсоолоос төлбөр авч байгаа нь замын түгжрэл үүсгэхэд нөлөөлж байна.

Томоохон худалдаа үйлчилгээний байгууллагуудад орлого оруулахын тулд нийслэлийн зам бөглөрч байна гэж хэлж болохоор байна. Энэ дүр зураг Бөмбөгөр худалдааны төв болон Барс захын түгжрэлээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл эдгээр худалдаа, үйлчилгээний байгууллагууд үйлчлүүлэгчээсээ машинаа зогсоолд нь зогсоосны төлөө төлбөр авч байгаагаас ихэнх үйлчлүүлэгч нь төлбөртэй зогсоолд машинаа тавихаас татгалзаж, авто замын 1 дүгээр энгээнд машинаа байрлуулсанаас замын бөглөрөл үүсгэж байна.

Барс зах нь өөрийн эзэмшлийн газартаа төлбөртэйгөөр машин зогсоодог. Хашаанд нь машинаа зогсооход 200 төгрөг, хашаанаас гарахдаа 500 төгрөгийн хураамж төлдөг аж. Тус захаар үйлчлүүлэгчид төлбөртэй зогсоолд тэр бүр машинаа тавьдаггүй. Тэр ч бүү хэл лангуу түрээслэгчдийн 110 машин өдөржин тус захын арын зам болох нарны зам дээр сойгддог. Уг нь "Нарны зам буюу Чулуун Овооноос Х хороолол хүртэлх замаар автомашинууд баруун, зүүн чиглэлээр саадгүй зорчих ёстой. Гэтэл "Барс" худалдааны төвийн ойролцоо түгжрэл үүссэнээр замын хөдөлгөөнд саад учруулаад зогсохгүй, осол их гарах болсон.

Баянгол дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн шугам замын байцаагч, дэслэгч н.Хадбаатартай хийсэн ярилцлагаас

Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамжийг эргэн харж, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.

ЛҮГНЭЛТ

- Аж ахуйн нэгж байгууллагууд ялангуяа Зах, буудал, дэлгүүр, нисэх буудал, вокзал зэрэг худалдаа үйлчилгээний байгууллагууд *тэр дундаа захуудаар үйлчлүүлэхээр орж ирсэн* тээврийн хэрэгсэл эзэмшигчээс төлбөр авах үзэгдэл өнөөдөр хэвийн үзэгдэл болсон байна.
- Эдгээр худалдаа, үйлчилгээний байгууллагууд Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамжыг үндэслэн иргэдээс зам ашигласны төлбөр авч буй хэдий ч засаг даргын тогтоосон төлбөрийн хэмжээнээс даруй 2-3 дахин их хэмжээний төлбөрийг иргэдээс авч байгаа хэдий ч захирамжийн дагуу нэг ч төгрөг Нийслэлийн замын санд төвлөрөөгүй байна.
- Захирамжийг зөрчиж төлбөрийг замын санд оруулахаас зайлхийж байгаа дээрхи байгууллагуудад захирамжид заасны дагуу хариуцлага тооцож хуулийн дагуу арга хэмжээ авсан тохиолдол байхгүй байна.
- Эдгээр байгууллагууд зогсоол ажиллуулснаас олж буй орлогоос зохих хувийг татварт төлж байна уу гэдгийг Татварын байгууллага цаашид анхаарах шаардлагатай байна.

Иймд Аж ахуйн нэгж байгууллагууд тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэдээс зам, зогсоол ашигласны төлбөр авах эрх зүйн үндэслэлтэй байна. Харин уг төлбөр авах эрх зүйн үндэслэл болсон Нийслэлийн засаг даргын захирамжын хэрэгжилт хангалтгүй, биелэлтийг хангах хөшүүрэг болсон хяналт нь сул байгаагаас иргэдийн мөнгө замын санд төвлөрөхгүй тухайн аж ахуйн нэгж байгууллагын орлого болж байна.

ЗӨВЛӨМЖ

Дээрхи мэдээлэл болон дүгнэлтийг үндэслэн Хүний Эрхийн Үндэсний Комиссоос:

- 2004 оны Нийслэлийн засаг даргын 49 дүгээр захирамжинд тавих хяналтыг сайжруулах, захирамжийг хэрэгжүүлэхгүй байгаа ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцох зэрэг асуудлыг тусгасан зөвлөмжийг захирамжаар үүрэг хүлээсэн эрх бүхий байгууллагад гаргах саналтай байна.

БОДЛОГО ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ БАГ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2004 оны 2 дугаар

ЖУРАМ БАТЛАН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2, "Авто замын тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 177 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах журмыг 1 дүгээр хавсралт, төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
- 2.Тээврийн хэрэгслээс тасалбар авах цэгийн байршил, тасалбар хураагчийн тусгай таних тэмдэг, зориулалтын хувцасны загварыг тогтоож хэрэгжүүлэхийг Нийслэлийн Зам тээврийн газар /Т.Пүрэвдорж/-т даалгасугай.
- 3.Нийслэлийн нутаг дэвсгэрийн төв хэсгийн хүн ам, тээврийн хэрэгслийн төвлөрөл ихтэй худалдаа, соёл, үйлчилгээний төвүүд, аж ахуйн нэгж байгууллагуудын орчимд 2004 оны 1 дүгээр улиралд багтаан 5-аас доошгүй авто машины зогсоолын талбайн газрын асуудлыг судалж шийдвэрлүүлэхийг Нийслэлийн Газрын алба /Б.Төмөрхуяг/-д даалгасугай.
- 4.Аж ахуйн нэгж байгууллагууд нийслэлийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс зам, зогсоол, талбай ашигласны төлбөр авч байгааг хүчингүй болгож энэхүү захирамжийн дагуу зохицуулахыг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.
- 5.Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замаар зорчиж байгаа авто тээврийн хэрэгслээс төлбөр авах ажлыг зохион байгуулах ажилтнуудын зардлыг төлбөрийн орлогоос гаргахаар тооцож бүтэц зохион байгуулалтыг баталж хэрэгжүүлэхийг Хотын ерөнхий менежер /Т.Бадамжунай/-т даалгасугай.

6.Энэхүү захирамжийг зөрчсөн иргэн, албан тушаалтанд Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байхыг эрх бүхий албан тушаалтнуудад даалгасугай.

7. Энэ захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Г.Галсанпунцаг/, Татварын газар /С.Энхбаатар/, Зам тээврийн газар /Т.Пүрэвдорж/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

ЖУРАМ БАТЛАН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ /

Нийслэлийн нутаг дэвсгэрт дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах журам/

2004 оны 2 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 49

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2, "Авто замын тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 177 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах журмыг 1 дүгээр хавсралт, төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Тээврийн хэрэгслээс тасалбар авах цэгийн байршил, тасалбар хураагчийн тусгай таних тэмдэг, зориулалтын хувцасны загварыг тогтоож хэрэгжүүлэхийг Нийслэлийн Зам тээврийн газар /Т.Пүрэвдорж/-т даалгасугай.

3. Нийслэлийн нутаг дэвсгэрийн төв хэсгийн хүн ам, тээврийн хэрэгслийн төвлөрөл ихтэй худалдаа, соёл, үйлчилгээний төвүүд, аж ахуйн нэгж байгууллагуудын орчимд 2004 оны 1 дүгээр улиралд багтаан 5-аас

доошгүй авто машины зогсоолын талбайн газрын асуудлыг судалж шийдвэрлүүлэхийг Нийслэлийн Газрын алба /Б.Төмөрхуяг/-д даалгасугай.

4. (Аж ахуйн нэгж байгууллагууд нийслэлийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс зам, зогсоол, талбай ашигласны төлбөр авч байгааг хүчингүй болгож энэхүү захирамжийн дагуу зохицуулахыг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замаар зорчиж байгаа авто тээврийн хэрэгслээс төлбөр авах ажлыг зохион байгуулах ажилтнуудын зардлыг төлбөрийн орлогоос гаргахаар тооцож бүтэц зохион байгуулалтыг баталж хэрэгжүүлэхийг Хотын ерөнхий менежер /Т.Бадамжунай/-т даалгасугай.

6. Энэхүү захирамжийг зөрчсөн албан тушаатанд Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байхыг эрх бүхий албан тушаалтнуудад даалгасугай.

7. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Г.Галсанпунцаг/, Татварын газар /С.Энхбаатар/, Зам тээврийн газар /Т.Пүрэвдорж/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА М.ЭНХБОЛД

2004 оны 2 дугаар сарын 24-ний өдөр улсын бүртгэлийн 2424 дүгээрт бүртгэсэн

Нийслэлийн Засаг даргын 2004 оны
49 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

**НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ АЖ АХУЙН ДОТООДЫН ЗАМААР
ЗОРЧИЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ТӨЛБӨР АВАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь: Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах асуудлыг Монгол Улсын Авто замын тухай хуулийн дагуу авто замын төлбөрийг нийслэлийн замын санд төвлөрүүлэхэд оршино.

1.2. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн дотоодын замаар зорчиж буй тээврийн хэрэгслээс юмчийн хэлбэрийг үл харгалзан төлбөр авахад үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Нийслэлийн авто замын санд орсон төлбөрийн орлого нь Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын дагуу зарцуулагдана.

1.4. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх Авто замын төлбөрийн орлогын гүйцэтгэлд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Татварын газар, Нийслэлийн Зам тээврийн газар тус тус хяналт тавина.

Хоёр. Төлбөр хураах журам

2.1. Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр уг замыг эзэмшигч хариуцна.

2.2. Төлбөр авах үйл ажиллагаа нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар зохион байгуулагдсан байна.

2.3. Тээврийн хэрэгслээс тогтоосон хэмжээний төлбөр авч тасалбар олгох, нэгдсэн нэг загвараар тасалбарыг гарган хэвлүүлж, дугаарлан баталгаажуулж аж ахуйн нэгж байгууллагад олгох ажлыг Нийслэлийн Зам тээврийн газар хариуцаж гүйцэтгэлд нь хяналт тавина.

2.4. Батлагдсан тасалбараас өөр тасалбар ашиглахыг хориглоно.

2.5. Тасалбар хураагч нь тусгай таних тэмдэг бүхий зориулалтын хувцас, хэрэгсэлтэй байна.

2.6. Төлбөр хураах цэг нь шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр /автомат хаалт гэх мэт/ хангагдсан байна.

2.7. Автомашины зогсоол, талбай ашигласны төлбөрийг давхардуулан авахгүй.

Гурав. Төлбөр тооцоо

3.1. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авсан төлбөрийн орлогын 40 хувийг Нийслэлийн замын санд төвлөрүүлнэ.

3.2. Авто тээврийн ачаалал ихтэй зогсоолын тайлбайгаас авах төлбөрийн хэмжээг зогссон цагаар нь тооцож авна.

3.3. Төлбөрийн орлогыг Нийслэлийн Зам тээврийн газрын дансанд хийж, сар бүрийн 25-ны дотор гүйцэтгэлийн тооцоо нийлж орлогыг НЗДТГ-ын Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэст шилжүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Төлбөртэй болгож буй зогсоол, тайлбайг хотын авто замын сүлжээний зурагт тэмдэглэж, нийтэд мэдээлж байна.

4.2. Дуут болон гэрлэн дохио ажиллуулан албан үүргээ гүйцэтгэж яваа эмнэлгийн түргэн тусламж, цагдаа, гал унтраах байгууллага, тусгай тэмдэглэгээтэй хяналт шалгалтын тээврийн хэрэгслээс төлбөр авахгүй.

4.3. Нийслэлийн Зам тээврийн газрын зөвшөөрөлгүйгээр/ энэхүү журамд зааснаас бусад(авто зам, авто/машины/зогсоол талбай ашигласны төлбөр авахыг хориглоно.

УИХ.МН
СҮДАЛГААНЫ САН

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь төлбөрийн орлогыг нуун дарагдуулсан, тасалбар хуурамчаар үйлдсэн, тасалбаргүй мөнгө хураасан нь илэрвэл холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Нийслэлийн Засаг даргын 2004 оны
49 дүгээр захирамжийн 2

дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ АЖ АХУЙН ДОТООДЫН ЗАМААР ЗОРЧИЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС АВАХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Төрөл	Хөнгөн тэрэг	Бага, дунд оврын автобус	/төгрөг/	
				Том оврын автобус	Ачааны авто машин, механизм
1.	Худалдаа, соёл үйлчилгээний төвүүд	100	100	200	1000
2.	Автомашин ы түр зогсоол, талбай	100	100	200	1000
3.	Авто машин ы байнгын зогсоол, талбай	500	500	500	500

Зогсоолын зардал, төлбөр болон орлогын тооцоо

Жанчивдоржийн Даваасүрэн, НАЗГ-ын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс

14-Май-09

"Зогсоолын зардал": Энэхүү хүснэгтэд зогсоолыг барих болон тоноглох зардлыг бодож тодорхойлов.

Жич: Өнгөөр будсан газарт өгөгдлийг оруулна уу. Бусад үнэлгээ АНУ-ын 2002 оны үнийн ханшаар доллараар авав.

Өгөгдөл /оруулах/


	Хотын гадна	Хот	Хотын төв	Гудамжинд	Тайлбар:
Газрын үнэ, акре	\$49 857	\$71,225	\$106,837	Varies	Газар худалдан авах үнэ
Зогсоолын талбай /хучсан/	110	120	130	250	Зогсоолын 1 акре буюу 4046.86м2 талбайд оногдох зогсоолын тоо /орц гарц болон ландшафт хамаарна/
Хөрөнгө өсгөх зэрэг	12%	12%	12%	12%	Хөрөнгө оруулалтыг удаан хугацаанд хийх сонирхолын зэрэг
Эрхлэх жил	20	20	20	20	Тооцоот жил
Сард төлбөртэй үйлчилгээ эрхлэх өдрийн тоо	20	20	22	25	Сард зогсоолын төлбөр авах өдрийн тоо

1

Тоног төхөөрөмжийн зардал

Төрөл	Билүү зогсоолын давхарын тоо	1 акре газрын үнэ, доллар	Нэгж зогсоолын газрын үнэ, доллар	Нэгж зогсоолын газрын нэг жилд оногдох үнэ, доллар	Нэгж зогсоолын талбай барих зам барилгын зардал, доллар	Зогсоолын талбайн зам барилгын зардлын жилд оногдох зардал, доллар	Нийт хөрөнгө оруулалт, доллар	Зогсоолын жилийн үйл ажиллагааны болон засвар, ариалгын зардал	Жилийн татвар	Жилийн нийт зардал, доллар	Сард оногдох зардал, доллар	Хонгт оногдох зардал, доллар
Хотын гудамж, зам дээр		\$71,225	\$285	\$38	\$650	\$87	\$935	\$62	\$0	\$187	\$16	\$0.62
Хотын ил зогсоол		\$71,225	\$594	\$79	\$650	\$87	\$1,244	\$130	\$0	\$296	\$25	\$1.24
Хотын 3 давхар зогсоол	3	\$71,225	\$198	\$26	\$5,000	\$669	\$5,198	\$100	\$0	\$796	\$66	\$3.32
Хотын газар доорхи зогсоол		\$71,225	\$0	\$0	\$5,000	\$669	\$5,000	\$100	\$0	\$769	\$64	\$3.21
Хотын төвд гудамж, зам дээр		\$106,837	\$427	\$57	\$650	\$87	\$1,077	\$50	\$0	\$194	\$16	\$0.65
Хотын төвд ил зогсоол		\$106,837	\$822	\$110	\$650	\$87	\$1,472	\$130	\$0	\$327	\$27	\$1.24
Хотын төвд 4 давхар зогсоол	4	\$106,837	\$205	\$28	\$5,000	\$669	\$5,205	\$100	\$0	\$797	\$66	\$3.02
Хотын төвд газар доорхи зогсоол		\$106,837	\$0	\$0	\$5,000	\$669	\$5,000	\$100	\$0	\$769	\$64	\$2.91
Тайлбар			Газрын үнийг билүү зогсоолын хувьд бүх хэрэглэгчдийн тоонд хувааж гаргав. Газар доорхи билүү зогсоолын хувьд газрын үнийг тооцож авахгүй.	Жилд оногдох газрын татвар	Зогсоолын тоног төхөөрөмжийн төлөвлөлт, зөвшөөрөл, зам барилгын өртөг	Жилийн барилгын ажлын зардал	Нийт хөрөнгө оруулалт /газар ба барилгын ажлын зардал нийлээд/, доллар	Засвар, ариалт, цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, газрын төлбөр, давтгал, захиргааны зардал, хяналтын зардал, хэрэгжүүлэлтийн зардал бүгд орсон зардал	Зогсоолын тоног, төхөөрөмжинд ноогдуулах үл хөдлөх хөрөнгийн татвар	Жилийн капитал болон үйл ажиллагаа, засварын нийт зардал, доллар	Жилийн нийт зардлыг 12 сард хувааж гаргасан.	Нэг сарын зардлыг сарын тооцоот өдрийн тоонд гаргасан зардал, доллар

Зогсоолын талбайн зардлын тооцоо



Төрөл	Нийт хөрөнгө оруулалт, доллар	Зогсоолын жилийн үйл ажиллагааны болон засвар, арчлалтын зардал	Жилийн нийт зардал, доллар	Сард оногдох зардал, доллар	Хоногт оногдох зардал, доллар
Хотын гудамж, зам дээр	\$935	\$62	\$187	\$16	\$0.62
Хотын ил зогсоол	\$1,244	\$130	\$296	\$25	\$1.24
Хотын 3 давхар зогсоол	\$5,198	\$100	\$796	\$66	\$3.32
Хотын газар доорхи зогсоол	\$5,000	\$100	\$769	\$64	\$3.21
Хотын төвд гудамж, зам дээр	\$1,077	\$50	\$194	\$16	\$0.65
Хотын төвд ил зогсоол	\$1,472	\$130	\$327	\$27	\$1.24
Хотын төвд 4 давхар зогсоол	\$5,205	\$100	\$797	\$66	\$3.02
Хотын төвд газар доорхи зогсоол	\$5,000	\$100	\$769	\$64	\$2.91

	1 згсл 18м2	100
Засвар, 10%	9,630	963,000
цэвэрлэгээ	18,000	1,800,000
газрын төлбөр	7,920	792,000
Гэрэлтүүлэг	5,000	500,000
Захиргаа	50,000	5,000,000
Дүн:	90,550	9,055,000
Хяналт	1,811	181,100
Даатгал	36	3,622
Дүн:	92,397	9,239,722
доллар	62	

	1 згсл 18м2	100
Засвар, 10%	9,630	963,000
цэвэрлэгээ	18,000	1,800,000
газрын төлбөр	7,920	792,000
Гэрэлтүүлэг	5,000	500,000
Захиргаа	150,000	15,000,000
Дүн:	190,550	19,055,000
Хяналт	3,811	381,100
Даатгал	76	7,622
Дүн:	194,437	19,443,722
доллар	130	

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Зогсоолын зардал, төлбөр болон орлогын тооцоо

"Зогсоолын төлбөр": Энэхүү хүснэгтэд зогсоолыг барихад зарцуулсан зардлыг эргүүлэн нөхөх ба үндсэн ашгийг бий болгох хэмжээний төлбөрийг бод
 Жич: Өнгөөр будсан газарт өгөгдлийг оруулна уу.

	Хотын гадна	Хот	Хотын төв	Гудамжинд	Тайлбар
Сард төлбөртэй үйлчилгээ эрхлэх өдрийн тоо	20	20	22	25	Сард зогсоолын төлбөр авах өдрийн тоо
Сарын ачааллын фактор, %	50%	80%	85%	85%	Зогсоолын талбайн ашиглалтын хувь
Жилийн ашиг	20%				Төлбөртэй зогсоолын үйлчилгээнээс төлөвлөж буй ашиг

Төрөл	Төлбөрийн систем	Зогсоолын жилийн зардал	Зогсоолын жилийн төлбөр	Жилийн нийт зардал	Сарын орлого	Өдрийн орлого	Сарын ашиг тооцогдсон орлого	Өдрийн ашиг тооцогдсон орлого
Хотын гудамж, зам дээр	Pay-And-Display	\$187	\$150	\$337	\$35	\$1.76	\$42	\$2.11
Хотын ил зогсоол	Pass, Pay-And-Display	\$296	\$150	\$446	\$47	\$2.33	\$56	\$2.79
Хотын 3 давхар зогсоол	Pass, Pay-And-Display	\$796	\$200	\$996	\$104	\$5.19	\$124	\$6.22
Хотын газар доорхи зогсоол	Pass, Pay-And-Display	\$769	\$200	\$969	\$101	\$5.05	\$121	\$6.06
Хотын төвд гудамж, зам дээр	Pass, Pay-And-Display	\$194	\$200	\$394	\$39	\$1.93	\$46	\$2.32
Хотын төвд ил зогсоол	Pass, Pay-And-Display	\$327	\$200	\$527	\$52	\$2.35	\$62	\$2.82
Хотын төвд 4 давхар зогсоол	Attendant	\$797	\$400	\$1,197	\$117	\$5.33	\$141	\$6.40
Хотын төвд газар доорхи зогсоол	Pass, Pay-And-Display	\$769	\$400	\$1,169	\$115	\$5.21	\$138	\$6.25

For details see "Pricing Methods", Online TDM Encyclopedia at <http://www.vipi.org/tdm/tdm83.htm>

Зардлын тооцооны хүснэгтээс

Төлбөрт орох нэмэгдэл зардал. Энэхүү зардал нь нэмэлт тоног төхөөрөмж, үйл ажиллагаа, захиргааны зардал орно.

Зогсоолын барилга, тоноглол, төлбөр багтсан нийт зардал

Сарын зардлыг бүрэн төлөх орлого

Өдрийн зардлыг бүрэн төлж чадах орлого

Сарын орлого /зардал, төлөвлөсөн ашиг тооцогдсон/

Өдрийн орлого /зардал, төлөвлөсөн ашиг тооцогдсон/

Зогсоолын төлбөрийн үндэслэл

	Хамгийн бага буюу 30 минутаар зогсох	Хамгийн их буюу 2 цагаар зогсох	Дундаж	
3161	2720	4760	3740	Цагийн хөлс: 30 мин-200 / 2 цаг-1400
4186	2720	5780	4250	Цагийн хөлс: 30 мин-200 / 2 цаг-1700
9336	6800	11900	9350	Цагийн хөлс: 30 мин-500 / 2 цаг-3500
9088	6800	11900	9350	Цагийн хөлс: 30 мин-500 / 2 цаг-3500
3479	4080	5100	4590	Цагийн хөлс: 30 мин-300 / 2 цаг-1500
4228	4080	6120	5100	Цагийн хөлс: 30 мин-300 / 2 цаг-1800
9601	9520	13600	11560	Цагийн хөлс: 30 мин-700 / 2 цаг-4000
9380	9520	13600	11560	Цагийн хөлс: 30 мин-700 / 2 цаг-4000

Зогсоолын зардал, төлбөр болон орлогын тооцоо

"Ашиг, орлого": Энэхүү тооцоогоор төлбөртэй зогсоолын үйлчилгээ хэрэгжсэнээр орох орлого ба ашгийг бодож тодорхойлно.

Тайлбар: Өнгөөр будсан газарт өгөгдлийг оруулна уу. Бусад үнэлгээ АНУ-ын 2002 оны үнийн ханшаар доллараар авав.

	Сарын орлого, доллар	Сарын ачааллын фактор, %	Жилийн нийт орлого	Жилийн нийт зардал	Жилийн цэвэр орлого	Маржины орлого
Хотын гудамж, зам дээр	\$42	85%	\$430	\$337	\$93	28%
Хотын ил зогсоол	\$56	80%	\$536	\$446	\$89	20%
Хотын 3 давхар зогсоол	\$124	80%	\$1,195	\$996	\$199	20%
Хотын газар доорхи зогсоол	\$121	80%	\$1,163	\$969	\$194	20%
Хотын төвд гудамж, зам дээр	\$46	85%	\$473	\$394	\$79	20%
Хотын төвд ил зогсоол	\$62	85%	\$632	\$527	\$105	20%
Хотын төвд 4 давхар зогсоол	\$141	85%	\$1,436	\$1,197	\$239	20%
Хотын төвд газар доорхи зогсоол	\$138	85%	\$1,403	\$1,169	\$234	20%

Хэрэглэгчдээс сард авах
орлого

Зогсоолын талбайн
ашиглалтын хувь

Нийт орлого

Жилийн зардал /тоног
төхөөрөмж, үйл
ажиллагаа, төлбөрийн
зардлууд бүгд
хамаарна/

Зардлууд хасагдсан
цэвэр орлого

Цэвэр орлогыг нийт
зардалд хувааж 100-аар
үржүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2009 оны 3 сарын 12

Дугаар 109

Улаанбаатар хот

Замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4/в/, 29.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Авто замын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний болон нийтийн тээврийн хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга	Нийслэлийн Засаг даргын орлогч /Барилга хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан/
Орлогч дарга	Хотын ерөнхий менежер
Гишүүд	Нийслэлийн Авто замын газрын дарга
	Замын цагдаагийн газрын дарга
	Нийслэлийн Тээврийн газрын дарга
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
	Замын цагдаагийн газрын дэд дарга бөгөөд хөдөлгөөний хяналтын хэлтсийн дарга
	Нийслэлийн Авто замын газрын орлогч дарга
	Улаанбаатар зам засвар, арчлалт компаний захирал
	Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн зам тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын Төлөвлөлт судалгааны албаны Зураг төслийн хэлтсийн дарга

Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын Хот байгуулалтын үйл ажиллагааг хянан зохицуулах хэлтсийн дарга

Нийслэлийн Газрын албаны орлогч дарга

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга

Замын цагдаагийн газрын Техник бүртгэлийн хэлтсийн дарга

Нийслэлийн Авто замын газрын Замын ашиглалт, хөдөлгөөний зохион байгуулалтын хэлтсийн дарга

Холбогдох дүүргийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга

Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөний зохион байгуулалтын хэлтсийн дарга

Хоёр. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох, замын ашиглалтыг сайжруулан авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тоноглол, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлэхийг нийслэлийн Засаг даргын Хууль зүйн хэлтэс /Ц.Түмэнбаяр/, Замын Цагдаагийн газар /Х.Энхжаргал/, нийслэлийн Авто замын газар / Д.Бат-Эрдэнэ/, нийслэлийн Нийтийн тээврийн газар / П.Наранцэцэг/, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Бямбасүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

1. Авто замын болон замын хөдөлгөөний менежментийг сайжруулах, нийтийн тээврийн сүлжээний төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдийг хэрэгжүүлэхэд Монголын талын гүйцэтгэх үүргийг хугацаанд нь чанартай гүйцэтгэх
2. Замын хөдөлгөөний бөглөрөл түгжрэлийг багасгах арга хэмжээг хот төлөвлөлтийн арга хэмжээтэй нягт уялдуулан авто машины зогсоолуудын ашиглалтыг сайжруулах, шинээр ил зогсоол болон төвлөрсөн зогсоолуудыг бий болгох, нийтийн эзэмшлийн зам талбайд явган хүний зам, замын хөдөлгөөнд саад учруулсан хашаа, барилга байгууламж, хаалт саад, рекламн байгууламжуудыг журамлаж цэгцлэх, холбогдох норм стандартыг шинээр боловсруулж хэрэгжүүлэх
3. Авто зам, замын байгууламжийн ашиглалтыг сайжруулан авто зам сэтлэж төрөл бүрийн шугам сүлжээ байгуулах, зогсоол карма байгуулах, явган зорчигчдын болон хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тоноглол техник хэрэгслийг шинэчлэн сайжруулах, үүнтэй холбогдсон норм стандартыг шинээр боловсруулж, тээврийн хэрэгслийн ачааллын тооллогыг тогтмол явуулж, хөдөлгөөний зохион байгуулалтын оновчтой шийдлүүдийг хэрэгжүүлэх, авто замын нэг чигийн хөдөлгөөнүүдийг бий болгох
4. Нийтийн тээврийн сүлжээг өөрчлөн зохион байгуулах замаар тээврийн төлөвлөлтийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэн, хотын төвийн хэсэгт нийтийн тээврийн хөдөлгөөнийг давуу эрхтэйгээр зохион байгуулах арга хэмжээ авах

5. Улаанбаатар хотын барилгажсан нутаг дэвсгэр хүрээгээ тэлж байгаатай уялдуудан шалган бүртгэх товчоодыг нүүлгэн шилжүүлэх газрын байршлыг шийдвэрлүүлэн, зураг төслийг зохиох, товчоод дээр авто машины техникийн хяналтын пост байгуулах тооцоо судалгаа хийж, барьж байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн барьж байгуулах
6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан техник хэрэгсэл, тоноглолуудыг бий болгох, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг санхүүжүүлж байх зорилгоор сан бий болгох тооцоо судалгаа хийж шийдвэрлүүлэх
7. Нийслэлийн зам тээврийн сүлжээг хөгжүүлэх, замын хөдөлгөөний менежментийг сайжруулах бодлогыг шинжлэх ухааны үндэстэй явуулж байх үүднээс Улаанбаатар хотод “Тээвэр судлалын төв” байгуулах асуудлыг судлаж хэрэгжүүлэх
8. Авто замын болон замын хөдөлгөөний менежментийг сайжруулах, нийтийн тээврийн сүлжээний төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр бусад ажлуудыг хийж гүйцэтгэх

Гурав. Замын хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох, нийтийн тээврийн төлөвлөлтийг сайжруулах эдгээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаад хяналт тавьж холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллахыг Хотын ерөнхий менежер /Ч.Бат/-т үүрэг болгосугай.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ**

Г.МӨНХБАЯР

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Тээврийн хэрэгслийн зогсоолын норматив

Рекреацийн, амралтын болон бусад барилга байгууламж	Хэмжих нэгж	Машины дээд хязгаарын тоо
1	2	3
Рекреацийн нутаг дэвсгэр ба амралт сувилалын барилга байгууламж		
Амралтын дэргэдэх пляжи ба парк	1 ээлжинд 100 үйлчлүүлэгч	20
Ойн парк ба дархан цаазат газар	"-	10
Түр хугацаагаар амрах бааз	"-	15
Гол мөрөн, далайн тээврийн зогсоол	"-	15
Амралт сувилал, санитори, жуулчдын бааз	100 үйлчлүүлэгч, амрагчид	15
Жуулчид, амрагчдын зочид буудал	"-	7
Мотел ба кемпенги	"-	Тооцоогоор
Амралтын дэргэдэх худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний цэг	Танхимд 100 хүн байхаар тооцох	10
Нөхөрлөл, цэцэрлэг	10 оролцогч	10
Яам, агентлаг, удирдах газар, банк санхүү, хуулийн байгууллага	100 хүн	20
улсын орон нутгийн	"-	7
Эрдэм шинжилгээ, их, дээд сургууль, коллежи	"-	15
Үйлдвэрийн газар	2 ээлжинд тус бүр 100 хүн	10
Эмнэлэг	100 ор	5
Поликлиник	100 хүн	3
Спортын барилга байгууламж, цэнгэлдэх хүрээлэн	100 хүн	3
Театр, цирк, кинотеатр, музей, үзэсгэлэнгийн танхим	100 байр	15
Соёл амралтын парк	100 хүн	7
Худалдааны төв, их дэлгүүр	100 ам/м талбай	7
Зах	50 худалдах цэг	25
Ресторан кафе	100 суудал	15
Дээд зэргийн зочид буудал	"-	15
Бусад зочид буудал	"-	8
Вокзал (бүх төрлийн)	100 зорчигч	15

Тайлбар.

- Амралтын дэргэдэх хөнгөн тэрэгний зогсоол хүртэл 1000 м.
- Амралт сувилалын, аялал жуулчлалын хот, тосгоны түүх, соёлын үзвэрийн газар хүртлэх зай хэмжээг 500 м байхаар тооцно.

УИХ МН
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, НИЙТИЙН МАШИН ЗОГСООЛ

Маркетингийн зөвлөх,
док. проф. Тулси Дарел

Социалист систем задран унаснаас хойш энэ улсын хөгжлийн үйл явц хурдацтай өөрчлөгдөж байгаа гэдэг ч олон хүмүүс энэ өөрчлөлт бүх газарт сайн эсвэл муу байна гэж төдийлөн итгэлтэй хэлж чадахгүй байгаа юм. Үнэн хэрэгтээ энэ өөрчлөлт тогтвортой бус байвал ирэх өдрүүдэд ихээхэн бэрхшээлтэй тулгарах болно.

Жил орчмын өмнө би Улаанбаатарт ирээд хотын хөгжил дэвшлийн асуудалтай (ялангуяа хотын бизнесийн хөгжлийн үйл ажиллагаанд) ихээхэн ойр нэгэн боломжийг олж харсан юм. Гэхдээ би энэ удаа эдгээр үйл ажиллагааг тайлбарлах гэсэн юм биш, зөвхөн Улаанбаатар хотод байнга өсөн нэмэгдэж байгаа замын хөдөлгөөний асуудлыг авч үзэн энэ асуудалд зарим нэг хариу өгөхийг зорьсон юм.

Замын хөдөлгөөний ид ачаалалтай үеэр тээврийн хэрэгслээр Наадмын талбайгаас Их дэлгүүр орё гэвэл хагас цаг магадгүй түүнээс ч илүү цаг зарцуулж магад. Энэхүү замын хөдөлгөөний удааширал олон зүйлээс шалтгаалдаг боловч замын хөдөлгөөн бүхий газар машин буруу тавих нь энэ байдлыг үүсгэж буй нэг гол шалтгаан мөн. Ингэж замбраагүй байдлаар машин тавих нь замын хөдөлгөөнд түгжрэл үүсгэдэг гэдгийг машинтай бүх хүмүүс мэддэг. Түүнчлэн олон машин тавьж болохуйц газар нэг хүн машинаа удаан хугацаагаар тавьж, тэр газрыг хурдан чөлөөлөх талаар огтхон ч бодохгүй явдаг.

Тэгэхээр дээрх нөхцөл байдлаас гарах ямар арга зам байна вэ?

Нийтийн машин зогсоолын газартай болох удаан боловч хялбар арга бол хотын захиргаанаас төлбөр тогтоох явдал. Энэ арга хаана ч хэрэглэгддэг, зүй ёсны зүйл. Дэлхийн бараг бүх том хотуудад нийтийн машин зогсоолын газраас төлбөр авдаг. Аль ч улсад нийтийн эзэмшлийн зам талбай нь хотын захиргааны мэдэлд байна. Энэ зориулалтын газраа үр ашигтай бүрэн дүүрэн ашиглаж, төсвийн орлогоо нэмэгдүүлэх нэг гол эх үүсвэр болгодог. Яагаад энэ аргыг Улаанбаатарт нэвтрүүлж болохгүй билээ? Үүнийг нэвтрүүлснээр ямар ашигтай вэ?

- Энэ арга бүх машин эзэмшигчдэд ашигтай. Учир нь машиныг зогсоолд тавихад гардаг бэрхшээлүүд арилна.
- Авто замын хөдөлгөөн чөлөөлөгдөж, түгжрэл үүсгэхгүй байх боломж бүрдэнэ.
- Машинаа шаардлагагүй үед удаан хугацаагаар зогсоолд орхих явдал зогсож нийтийн машин зогсоолын газарт машинаа тавиад “мартчихдаг” жолооч нарт туслана.
- Автомашин хэрэглээндээ хүмүүс илүү болгоомжтой хандах болж ингэснээр орчинд тойронд үзүүлэх сөрөг нөлөө багасан, хотыг цэвэр үзэмжтэй байлгахад нэмэр болно.
- Хотын захиргаа үүнээс хотыг хөгжүүлэх үйл ажиллагаандаа нэмэр болохуйц орлого олох боломжтой.

Би энэ төслийн талаар хотын захиргаанд танилцуулсан бөгөөд хотын удирдлага зарчмын хувьд хүлээн зөвшөөрч дэмжлэг үзүүлэхээ

Танилцуулга

Монгол улсын Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар “Хууль бус төлбөр, хураамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” хэлэлцсэн. Энэ хуралдааны 60-р тэмдэглэлд тэмдэглэснээр Нийслэл дэх худалдааны томоохон зах, вокзал, аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоодын авто зам, замын байгууламж, талбайгаар зорчих болон нэвтрэн орж байгаа тээврийн хэрэгсэл, иргэдээс төлбөр, хураамж авах асуудлыг шийдвэрлэх үүргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын даргад өгсөн.

Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын 2004 оны 02 сарын 10-ны өдрийн 49 тоот захирамж гарсан. Захирамжийн дагуу манай байгууллагаас нийслэлийн хэмжээнд төлбөртэй зогсоолын талбайн үйлчилгээ явуулдаг томоохон зах, аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж эхний ээлжинд Нийслэлийн Газрын албанд 2004-01-19 –нд 2/43 тоотой нарийвчлан материалыг тодруулж авахаар албан бичиг өгсөн боловч өнөөдрийг хүртэл шийд өгөхгүй хүлээгдэж байна.

СБД, ЧД, ХУД, БЗД, СХД, БГД-ын Засаг дарга нарт 2004-02-24-нд 2/118 тоотой Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх талаар албан бичиг явуулсан.

Мөн дүүргүүдээс аж ахуйн нэгжийн дотоодын замаар зорчиход төлбөр авч байгаа болон ил, байнгын зогсоолын үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгжийн судалгааг авахаар 2004 оны 03-р сарын 12-нд 2/163 тоот албан бичгээр СБД, БГД, ХУД, ЧД, БЗД, СХД –дэд явуулаад байна. Хан-уул, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын ТҮҮХ- ээс дарга нар нь ярьж өөрсдийн дүүрэг дээр төлбөр авч байгаа газруудыг гаргаж хамтран ажиллахаар тохиролцоод байна.

Хотын томоохон зах болох Наран туул зах, Да хүрээ зах, Цайз зах, Хүчит шонхор зах, Бөмбөгөр худалдааны төв, Хар хорин зах, Барс зах, Хангай зах, Таван эрдэнэ зах, Вокзал зэрэг 10 байгууллагуудын удирдлагаас эхний ээлжинд 2004 оны 02 сарын 11-13-ны хооронд Наран туул захын захиралтай саналаа солилцохоор урьсан боловч ирээгүй.

Иймд бусад байгууллагуудын удирдлагыг мөн сарын 16-18-нд урихад цагаан сарын дараа уулзана гэсэн. Үүний дагуу цагаан сарын дараа дахин байгууллагуудын удирдлагуудыг урихад өнөөдрийн байдлаар Наран туул зах, Цайз зах, Бөмбөгөр, Вокзал, Барс захын удирдлагуудтай биечлэн уулзаж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Засаг даргын захирамжийг танилцуулж саналаа солилцсон. Эдгээр байгууллагууд өөрсдийн саналыг албан тоотой манайд ирүүлэхээр болсон ба албан ёсоор хариу ирээгүй байна.

НЭГ. ТӨЛБӨРТЭЙ ЗОГСООЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮНДЭС, ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1.1 ОРШИЛ

Монгол улсын нийслэл Улаанбаатар бөгөөд бүх хүн амын 40 гаруй хувь энд оршин суудаг. Жил бүр тус хотод хөдөө орон нутгаас хүмүүс олноор шилжин ирж суурьшиж байгаагаас тус хотын хүн амын тоо огцом өсөж байгаа юм. Үүний зэрэгцээ манай орны нэг өрх болгоны нэг хүн гадаадад ажиллаж амьдарч байгаа. Тэд сар бүр гэр орон руугаа мөнгө явуулж, тэр мөнгөөр нь энд байгаа гэрийнхэн нь голдуу хэрэглээ тал руугаа буюу байр орон сууц, автомашин худалдаж авах зэргээр зарцуулж байдаг. Энэ нь улс орны эдийн засагт төдийлөн сайн биш юм. Яагаад гэвэл үйлдвэрлэл тал руугаа биш хэрэглээ тал руугаа мөнгөө зарцуулаад байхаар үйлдвэрлэлийн эдийн үасаг өсөхгүй байдаг.

Манай оронд зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс хойш хотын хүмүүсийн амьдралын хэв маяг барууны болон хөгжингүй орнуудынхтай адил болж байгаа билээ. Автомашин бол хотын олонхи хүмүүсийн онцгой хэрэглээний нэг болоод байна. Жил бүр автомашин хэрэглэгчдийн тоо огцом өсөж байна.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд хатуу хучилттай 361 км авто замаар 78000 орчим автомашин хөдөлгөөнд оролцож байна. Хотын замын хөдөлгөөний энэхүү дарамт нь замын хөдөлгөөнийг системчлэх, түүнийг бууруулах талаар арга хэмжээ авах цаг нэгэнт болсныг харуулж байна. Үүний тулд хотын захиргаа энэ асуудалд онцгой анхаарал хандуулж тохиромжтой арга хэмжээг хайх хэрэгтэй.

Түүнчлэн одоогоор замын хөдөлгөөний удаашралын гол шалтгаан болох хууль бусаар автомашин зогсоолд тавих асуудлыг зохицуулах механизм алга байна. Хотын автомашины зогсоолын талбай маш хязгаарлагдмал хийгээд байнга дүүрэн байдаг. Автомашины ил зогсоолд цагийн хязгаар гэж байхгүй, хүмүүс машинаа заримдаа өдөржин тавьдаг. Тэдгээр машиныг шилжүүлэх тэндээс зайлуулах талаар ямар нэг систем гартал тэд энэ талаар огт санаа тавихгүй.

Хотын автомашины зогсоолын асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн арга бол автомашины ил зогсоолын талбайг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх төлбөрт үйлчилгээ бүхий талбайг бий болгох Нийслэлийн санд орлогын шинэ эх үүсвэр бий

Энэ зориулалтын газраа үр ашигтай бүрэн дүүрэн ашиглаж төсвийн орлогоо нэмэгдүүлэх нэг гол эх үүсвэр болдог. Яагаад энэ аргыг Улаанбаатар хотод нэвтрүүлж болохгүй билээ. Үүнийг нэвтрүүлснээр ямар ашигтай вэ?

1. Энэ арга бүх автомашин эзэмшигчдэд ашигтай. Учир нь автомашиныг зогсоолд тавихалд гардаг бэрхшээлүүд арилна.
2. Авто замын хөдөлгөөн чөлөөлөгдөж, түгжрэл үүсгэхгүй байх боломж бүрдэнэ
3. Машинаа шаардлагагүй үед удаан хугацаагаар зогсоолд орхих явдал зогсож нийтийн автомашин зогсоолын газарт машинаа тавиад “мартчихдаг” жолооч нарт тусална
4. Автомашин хэрэглээндээ хүмүүс илүү болгоомжтой хандах болж ингэснээр орчин тойронд үзүүлэх сөрөг нөлөө багасан, хотыг цэвэр үзэмжтэй байлгахад нэмэр болно.
5. Хотын захиргаа үүнээс хотыг хөгжүүлэх үйл ажиллагаандаа нэмэр болохуйц орлого олох боломжтой.

Нийслэлийн нутаг дэвсгэр дэх автомашины ил зогсоолын талбайд зогссон тээврийн хэрэгслээс төлбөр авах асуудлыг Монгол улсын Авто замын тухай хуулийн дагуу уг төлбөрийг Нийслэлийн замын санд төвлөрүүлэхэд оршино.

Иймд Нийслэлийн Авто замын санд орсон төлбөрийн орлого нь Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын дагуу “Орон нутгийн авто замын санг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, тохижуулах, мэргэжлийн хяналт тавихтай холбогдон гарах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна”.

2.3 Одоо төлбөр авч байгаа зогсоолуудын жасгаалт

№	Зогсоолын талбайн нэр	Зогсоолын талбайн байршил	Харьяалах байгууллага, аж ахуйн нэр	Газар эзэмших гэрээтэй эсэх
1	Нарантуул худалдааны төв ✓	БЗД	Нарантуул ХХК	Гэрээгээ баталгаажуулсан
2	Барс худалдааны төв ✓	БГД	Барс импекс ХХК	Гэрээгээ баталгаажуулсан
3	Хархорин зах ✓	СХД	Чингис трейд ХХК	Гэрээгээ баталгаажуулсан
4	Хүчит шонхор худалдааны төв ✓	ЧД	Хүчит шонхор ХХК	Гэрээгээ баталгаажуулсан

5	Найман шарга зах	ЧД		Гэрээгээ баталгаажуулсан
6	Да хүрээ зах	БЗД	Даймонд ХХК	Гэрээгээ баталгаажуулсан
7	Өгөөмөр зах	БЗД		Гэрээгээ баталгаажуулсан
8	Вокзал	БГД	Улаанбаатар ертөө	Гэрээгээ баталгаажуулаагүй
9	Тэнгис кинотеатр	ЧД		Гэрээгээ баталгаажуулсан
10	Замын цагдаа Жуулчны бааз	СБД	Жуулчны бааз ХХК	Гэрээгээ баталгаажуулсан
11	Засгийн газрын 4-р байр	ЧД		Гэрээгээ баталгаажуулсан
12	ШУТИС	СБД	Шинжлэх ухаан технологийн их сургууль	Гэрээгээ баталгаажуулаагүй
13	Гутлын үйлдвэр	ХУД	Гутал ХК	Гэрээгээ баталгаажуулсан
14	Улаанбаатар төмөр замын Ачиж буулгах механикжсан анги	БГД	Улаанбаатар төмөр замын Ачиж буулгах механикжсан анги	Гэрээгээ баталгаажуулаагүй

15 *Ишээр***2.4 Ил зогсоолын талбайгаас авах төлбөрийн хэмжээ**

/төгрөгөөр/

№	Төрөл	Хөнгөн тэрэг	Бага дунд оврын автобус/микро/	Том оврын автобус	Ачааны автомашин, механизм
1	Автомашинны түр зогсоол, ил зогсоолын талбай	100	100	200	1000
2	Автомашинны байнгын зогсоол, талбай	500	500	500	500
3	Худалдаа, соёл үйлчилгээний төвүүд	100	100	200	1000

/журмаас авав/

Хавсралт №1

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Тайлбар
1	Нарантуул худалдааны төв	БЗД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
2	Барс худалдааны төв	БГД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
3	Хар хорин зах	СХД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
4	Хүчит шонхор худалдааны төв	ЧД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
5	Найман шарга зах	ЧД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
6	Да хүрээ зах	БЗД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
7	Өгөөмөр зах	БЗД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
8	Вокзал	БГД	Газар эзэмших гэрээ байгуулаагүй
9	Тэнгис кинотеатр	ЧД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
10	Замын цагдаа жуулчны газар	СБД	Газар эзэмших гэрээ байгуулаагүй
11	Засгийн газрын 4-р байр	ЧД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
12	ШУТИС	СБД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
13	Гутлын үйлдвэр	ХУД	Газар эзэмших гэрээ байгуулсан Баталгаажилтийн схем зурагтай
14	Улаанбаатар төмөр замын ачиж буулгах механикжсан анги	БГД	Газар эзэмших гэрээ байгуулаагүй

**Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа
явуулж байгаа автомашины ил зогсоолын судалгаа**

2004-03-22

№	Байгууллага, аж ахуйн нэгж, эзний нэр	Хороо	Байршил
1	Хувь иргэн Эрдэнээ	18	22-ын а, б байрын дэргэд
2	Хувь иргэн Лхагвасүрэн	18	Хангай хүнсний дэлгүүрийн дэргэд
3	Хувь иргэн Энх-Амгалан	14	12-р байрны хүүхдийн тоглоомын талбай
4	Их Хөдөлгөөн ХХК	14	14-р байрны дэргэд
5	Мон-Инж-Бар ХХК	15	Компанийн хашаанд
6	Буурал аав ХХК	17	Өөрийн хашаанд
7	Эрүүл мэндийн нэгдэл	13	Өөрийн хашаанд
8	Хувь иргэн Нарансайхан	19	8-ын а, б байрны дэргэд
9	Хувь иргэн Болдхуяг	19	7-ын в байрны дэргэд
10	Хувь иргэн Эрдэнэбаяр	19	4-р 48 айлын зүүн талд
11	Хувь иргэн Даваадорж	20	Бага номт дэлгүүрийн дэргэд
12	Дөргөн нуур ХХК	16	Өөрийн байрны дэргэд

Б. Юмшпил 62 р сургууль 19

Сургуулийн хашаанд

Судалгаа гаргасан ЗДТГ-ын ТҮҮХ-ийн дэд бүтэц хариуцсан
Зохион байгуулагч

Л. Алтанхуяг

**Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвгэр дээр дотоодын авто замаас
төлбөр авч байгаа аж ахуйн нэгж байгууллагын судалгаа**

2004-03-22

1. Драгон төвийн дэргэдэх авто вокзал	300 төг
2. Олон улсын хүүхдийн Найрамдал зуслан	500 төг
3. Нуман цагаан ХХК	100 төг

4. Хархорин зах.

Засаг даргын тамгын газрын ТҮҮХ-ийн
зохион байгуулагч

Л.Алтанхуяг

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

**Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт аж ахуйн дотоод замаас төлбөр авч
байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын судалгаа**

2004-03-25.

№	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Хариуцсан захирал эзний нэр	Байршил	Авч байгаа татвар хураамжийн хэмжээ
1.	Нарантуул зах ОУХТөв	Менежер Ганчулуун Утас 457021	14-р хороо	Гарч байгаа машинаас 100 төг хураадаг.
2.	Да хүрээ трейд ХХК Техникийн зах	Захирал Даш утас	17-р хороо	Авдаг
3.	Цолмонбадрах ХХК Модны зах	Захирал Оюунбилэг Утас 91110316	5-р хороо Цайз захын баруун урд	Тасалбар өгөөд 200 төгрөг авдаг.
4.	Хайтан ХХК Модны зах	Захирал Жаргалсайхан 99184700	5-р хороо Цайз захын урд	Авдаггүй
5.	Нармон ХХК Модны зах	Захирал Хүрэлсүх 99115267	14-р хороо Нарантуул захын зүүн талд	Авдаггүй
6.	"Дако" авто сервис Автомашинны зогсоол	95253308 95257086	17-р хороо Да хүрээ захын дэргэд	Авдаг
7.	"Даймонд" ХХК Автомашинны зогсоол		17-р хороо Да хүрээ захын дэргэд	Авдаг
8.	"Зэв"концерн УҮГ Модны зах	Захирал Л.Батсүх 95158016	16-р хороо ЦИС-ийн зүүн талд	Авдаггүй
9.	"Баянзүрх" хүнсний зах	Захирал Буянхишиг 459363	6-р хороо "Өрнөлт од" ХХК	Жижиг машин 100 Ачаа машин 200
10.	"Агч" формула ХХК Дулаан гараш	Захирал Хулан 99164102 481436	4-р хороо хуучнаар 27-р авто бааз	хувийн

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

**УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ
“ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨЛБӨРТЭЙ ЗОГСООЛ”
ЭРХЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн зогсоолын талбайд төлбөртэй үйлчилгээг бий болгож, зогсоолын ашиглалтыг сайжруулах, хөдөлгөөний дэг журмыг хэвшүүлэн тогтоохтой холбогдсон үйлчилгээ эрхлэх байгууллага /зогсоолын эзэмшигч/ болон үйлчлүүлэгчийн /авто зогсоолыг ашиглагч/ хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Монгол улсын Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалт, 7 дугаар зүйлийн 7.1 заалт, 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйлүүдийг мөн Автотээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.7 дахь заалтыг үндэслэн энэхүү журмыг боловсруулсан болно.
- 1.3. Журмыг хэрэгжүүлэх ажлыг Нийслэлийн Авто замын газар хариуцан зохион байгуулж, тээврийн хэрэгсэлийн зогсоолын төлбөрийн орлогын гүйцэтгэлд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Татварын газар, Нийслэлийн Авто замын газар тус тус хяналт тавина.
- 1.4. Нийслэлийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн талбай дахь тээврийн хэрэгслийн зогсоолын талбайгаас төлбөр авч байгаа бүх үйлчилгээ энэхүү журмын дагуу зохицуулагдана.

Хоёр. Нэр томъёоны ойлголт

- 2.1 *Авто зогсоол*
- зөвхөн автомашины зогсоолын буюу автомашиныг хадгалах зориулалтаар байгуулсан барилга, байгууламж, түр буюу удаан хугацаагаар хадгалах зориулалтын талбай
- 2.2 *Гудамжны гаднах задгай ил зогсоол*
- хотын эзэмшлийн буюу харьяалагдах, гудамжны гаднах газарт байрлах, тээврийн хэрэгсэл зогсоох зориулалтын талбайг ойлгоно.
- 2.3 *Гудамж, зам дээрх зогсоол*
- гудамж, замын зурвасын орон зай дахь тээврийн хэрэгслийг түр болон удаан хугацаагаар зогсоох зориулалтын зогсоолыг ойлгоно.
- 2.4 *Битүү зогсоол*
- инженерийн хангамжийн байдлаараа халаалттай болон халаалтгүй, газрын гадаргуутай харьцах байрлалаараа газар доорхи ба газар дээрх гэсэн байрлалаар нэг болон хоёр түүнээс олон давхар зогсоолд байрлуулалтаараа өөрийн явалтаар мөн цахилгаан өргүүрээр байрлуулагдах зогсоолыг ойлгоно.
- 2.5 *Механикжсан зогсоол*

- жолоочийн оролцоогүйгээр, зориулалтын механикжсан төхөөрөмжөөр авто тээврийн хэрэгслийг хадгалах зогсоол зөөвөрлөн байрлуулах боломжтой зогсоол,
- 2.6. *Авто тээврийн хэрэгсэл*
 - ачаа болон зорчигч, тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн ачааны болон суудлын автомашин, автобус, чирэгч, чиргүүл, хагас чиргүүл,
- 2.7. *Зогсоолын эзэмшигч*
 - ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгслийг байрлуулахаар зогсоол төлөвлөж байгуулсан барилга, байгууламж эзэмшигч буюу ашиглагч этгээд,
 - нийтийн хэрэгцээнд зориулж авто тээврийн хэрэгслийг төлбөртэйгээр байрлуулах, хадгалах ажил үйлчилгээ эрхлэгч этгээд,
- 2.8. *Зогсоолын төлбөрийн төхөөрөмж*
 - зогсоолоор үйлчлүүлсэний төлбөрийг авахад зориулагдсан механик болон электрон төхөөрөмжийг ойлгоно.
- 2.9. *Өдрийн цагийн зогсолт*
 - зогсоолын төлөвлөлтгүй баригдсан бөгөөд зогсоол хүрэлцээгүй буй олон давхар байрны гадна өдрийн цагаар буюу 09:00 цагаас 18:00 цаг хүртэлх хугацаанд тээврийн хэрэгсэл зогсоох зөвшөөрөл
- 2.10. *Шөнийн цагаар тээврийн хэрэгслийн зогсолт*
 - хорооллын доторхи 2-оос илүү урсгалтай авто замын гадна талын зурвасуудад 02:00 цагаас 6:00 цагийн хооронд тээврийн хэрэгсэл зогсоохыг.
- 2.11. *Өвлийн улиралд тээврийн хэрэгслийн зогсолт*
 - Улаанбаатар хотод 11 дүгээр сарын 1-ээс 3 дугаар сарын 15 хооронд гудамж, замууд дээр тээврийн хэрэгслийг зогсоохыг.
- 2.12. *Албан байгууллага нягт байрласан бүс газарт амьдрагч иргэдэд өгөх зөвшөөрөл*
 - Улаанбаатар хотын Их тойруугийн тойрог замын доторхи бүс газрыг албан байгууллага нягт байрласан бүс газарт хамааруулж, тухайн бүсэд оршин суух иргэдэд олгох зөвшөөрөл.
- 2.13. *Зогсоолын төлөвлөлтгүй байр, орон сууцанд амьдрагч иргэдэд өгөх зөвшөөрөл*
 - “Барилга, хот байгуулалт” БНБД ... заалтын хүснэгт ... –д заасан тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн нормативыг хангаагүй байр, орон сууцанд оршин суугчдад олгох зөвшөөрөл

Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага

- 3.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар нь Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллага байна.
- 3.2. Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийг /зогсоолын эзэмшигч/ зогсоолын төрлөөс хамааруулж сонгоно.

- 3.3. Нийслэл хотод тээврийн хэрэгслийн зогсоолын төлбөрийн хэмжээг Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дүгээр заалтыг үндэслэн Засаг даргын захирамжаар тогтооно.

Дөрөв. Хэрэгжүүлэгч байгууллагын эрх, үүрэг

- 4.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар нь тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээг хэрэгжүүлэх талаар дараахь эрх эдэлнэ:
- 4.1.1 Авто замын тухай, Авто тээврийн тухай хууль болон авто зогсоолын норм, стандартын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд тодотгол, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх,
- 4.1.2 Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээг хөгжүүлэх болон түүнтэй холбоотой техник, технологийн талаархи орон нутгийн төрийн захиргааны байгууллагын бодлогыг хэрэгжүүлэх;
- 4.1.3 Хотын тээврийн хэрэгслийн зогсоолын жилийн төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрт нийцүүлэн боловсруулах;
- 4.1.4 Хотын тээврийн хэрэгслийн зогсоолын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулах;
- 4.1.5 Хотын тээврийн хэрэгслийн зогсоолын хөрөнгийн хуваарийг батлах, сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих;
- 4.1.6 Зогсоолын үйлчилгээний үнэ тариф, төлбөртэй цагийн хуваарийг тогтоох;
- 4.1.7 Зогсоолыг эзэмшигч, ашиглагч нь тээврийн хэрэгслийн зогсоолын түрээсийн төлбөрийг сар, улирал, жилээр урьдчилан төлсөн тохиолдолд үзүүлэх үнийн хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох.
- 4.1.8 Зогсоолын үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагуудыг сонгон шалгаруулж, ажиллуулах.
- 4.2. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар нь дараахь үүрэг хүлээнэ:
- 4.2.1 Хэрэгжүүлэгч байгууллага нь зогсоолын үйлчилгээнээс орох орлогыг зөвхөн Нийслэлийн замын санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах
- 4.2.2. Хотын тээврийн хэрэгслийн зогсоолын тухай журам, стандартыг боловсруулж, батлуулах;
- 4.2.3. Хотын тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудыг холбогдох стандарт, техникийн шаардлагаар хангуулах;
- 4.2.4. Зогсоолын үйлчилгээ эрхлэхээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 4.2.5. Зогсоолын үйлчилгээний талбайн эрэлт хэрэгцээг тооцож, судалгаа хийх, шинээр байгуулах;
- 4.2.6. Зогсоолын үйлчилгээг боловсронгуй болгох

Тав. Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын / Зогсоолын эзэмшигч / эрх, үүрэг

- 5.1. Зогсоолын үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллага нь дараахь эрх эдэлнэ.
 - 5.1.1. Үйлчлүүлэгчдээс зогсоолын үйлчилгээтэй холбоотой хууль, дүрэм, журмыг биелүүлэх шаардлага тавих;
 - 5.1.2. Хэрэгжүүлэгч байгууллагаас тээврийн хэрэгслийн зогсоолтой холбоотой стратеги бодлого, төлөвлөгөө, хууль, журам болон бусад холбогдох хууль зүйн актыг шаардах;
 - 5.1.3. Зогсоолын үйлчилгээний орлогыг Нийслэлийн Авто замын санд төвлөрүүлэх
 - 5.1.4. Зогсоолын техникийн нөхцөл, шаардлагыг хангахгүй, галын болон бусад төрлийн аюултай, мөн хэт хүнд даацын, эсвэл даац хэтрүүлсэн тээврийн хэрэгсэлд зогсоолоор үйлчлэхээс татгалзах;
- 5.2. Зогсоолын үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллага нь дараахь үүрэг хүлээнэ:
 - 5.2.1. Хариуцаж буй зогсоолын үйлчилгээг холбогдох хууль, журмын хүрээнд эрхлэх;
 - 5.2.2. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхтэй холбоотой тавьсан шаардлагыг хуулийн хүрээнд биелүүлэх;
 - 5.2.3. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэвээр хадгалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөгдсөн зогсоолоор үйлчлүүлэгчидэд үйлчлэх;
 - 5.2.4. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас Хэрэгжүүлэгч байгууллагатай тохиролцсон үнэ тариф, цагийн хуваарийг баримтлах;
 - 5.2.5. Хэрэгжүүлэгч байгууллагад сар, улирал, жилээр үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргаж өгөх;
 - 5.2.6. Зогсоолын тохижилтын асуудлыг бүрэн хариуцаж, шаардлагатай засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэж байх;
 - 5.2.7. Зогсоолын ажилчдыг зориулалтын хувцас, хөдөлмөрийн багаж, шаардлагатай тоног, төхөөрөмж болон бусад хэрэгслээр хангах;

Зургаа. Төлбөртэй зогсоолоор үйлчлүүлэгчдийн эрх, үүрэг

- 6.1. Зогсоолоор үйлчлүүлэгчид нь дараахь эрх эдэлнэ:
 - 6.1.1. Үйлчлүүлэгчид нь тээврийн хэрэгслийн техникийн нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангасан зогсоолоор үйлчлүүлэх;
 - 6.1.2. Хэрэгжүүлэгч байгууллагад тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолтой холбоотой санал, гомдол, хүсэлт гаргах;
 - 6.1.3. Зогсоолын үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл авах;
 - 6.1.4. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагууд нь нийтийн эзэмшлийн зам, талбай дах тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын 30 хүртэлх хувийг урьдчилсан төлбөртэйгээр сар, улирал, жилээр түрээсэлж болно. Энэ тохиолдолд төлбөрийн хөнгөлөлт эдлэнэ.

- 6.2. Зогсоолоор үйлчлүүлэгчид нь дараахь үүрэг хүлээнэ:
 - 6.2.1. Зогсоолын техникийн нөхцөл, шаардлагыг хангах, эсвэл галын болон бусад төрлийн аюулгүй, ачаа даац хэтрээгүй тээврийн хэрэгслийг зогсоолд тавих;
 - 6.2.2. Үйлчлүүлэгчид нь тээврийн хэрэгсэл тавихыг хориглосон, зогсоолын бус газарт автомашиныг тавихгүй байх;
 - 6.2.3. Зогсоолын үйлчилгээний төлбөрийг төлөх;

Долоо. Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйлчилгээ

7.1. Зогсоолын өдрийн цагийн үйлчилгээний журам:

- 7.1.1. Зогсоолын цагийн хуваарь байгаа тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоолд заасан хуваарийн дагуу тавина;
- 7.1.2. Зогсоол хангалтгүй орон сууцанд амьдардаг, байнгын оршин суугчдад, өдрийн цагийн зогсоолын зөвшөөрлийг олгоно. *Зогсоолын төлөвлөлтгүй байр, орон сууцанд амьдрагч иргэдэд өгөх зөвшөөрөл*
- 7.1.3. Үйлдвэр, сургууль, эмнэлэг, эсвэл төвлөрсөн болон төрөлжсөн худалдааны төв зэрэг орон нутгийн төр захиргааны байгууллагаас “Албан байгууллага төвлөрсөн” гэж тодорхойлсон дүүрэгт амьдардаг оршин суугчдад өдрийн цагийн зогсоолын зөвшөөрлийг олгоно. *Албан байгууллага нягт байрласан бүс газарт амьдрагч иргэдэд өгөх зөвшөөрөл*
- 7.1.4. Хотын зогсоолын талбай болон төвлөрсөн дотор зогсоолын үйлчилгээний талаарх мэдээллийг www.autozam.ub.gov.mn веб хуудаснаас үзнэ үү.

7.2. Зогсоолын шөнийн цагийн үйлчилгээний журам:

7.2.1. Зогсоолоор шөнийн цагт үйлчлүүлэх зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслүүдийг шөнө 02:00 – 6:00 цагуудын хооронд гудамжинд зогсохыг дараахь нөхцлүүдээс бусад тохиолдолд зөвшөөрнө.

Үүнд:

- Бүтэн сайн өдрийн өглөө
 - Шинэ жилийн баяр, тусгаар тогтнол, наадам, цагаан сар зэрэг тэмдэглэлт өдрүүдийн өглөө
 - Шөнийн цагуудад бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн дүүрэг, газрын гудамжинд 1 цагаас илүү зогсохгүй байх
 - Тодорхой хөдөлгөөн ихтэй гудамжуудад 11 дүгээр сарын 1-ээс 3 дугаар 15 хүртэл хугацаанд тээврийн хэрэгсэл зогсохыг зөвшөөрөхгүй.
- 7.2.2. Өвлийн улиралд цасан шуургатай өдөр, шөнийн цагийн зогсоолын үйлчилгээний журам нь орой 23:00 – с өглөөний 6.00 хүртэл цагийн хооронд, тавихыг зөвшөөрсөн /тээврийн хэрэгслийг өвлийн улиралд зогсохыг зөвшөөрсөн/ гудамж, замууд дээр хэрэгжинэ.

7.3. Өвлийн улирлын хугацаан дахь зогсоолын үйлчилгээний журам:

- 7.3.1. Өвөл 11 дүгээр сарын 1-ээс 3 дугаар сарын 15 хүртэл хугацаанд хотын гол гудамж замд зогсохыг хориглоно.
- 7.3.2. Өвөл 11 дүгээр сарын 1-ээс 3 дугаар сарын 15 хүртэл хугацаанд шөнийн цагт хорооллын дотор 2-оос дээш урсгалтай замын гадна зурвасын зөвхөн нэг талд нь зогсохыг зөвшөөрнө.

Найм. Зогсоолын үйлчилгээний төлбөр

- 8.1. Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын төлбөрийн хэмжээг хамгийн багадаа дараахь зардлуудыг багтаасан байхаар тооцож тогтооно.
 Үүнд:
 - Зогсоолын үйл ажиллагааны зардал
 - Зогсоолын барилга, талбайн зардал
 - Зогсоолын тоног төхөөрөмжийн зардал
 - Зогсоолын үйлчилгээний барилгын зардал, ашиглагдаж байх дундаж хувь 85-90% байхаар тооцож 7.2.-т өгсөн тарифыг өөрчлөн тогтоох.
- 8.2. Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн зогсоолын төлбөрийн хэмжээ нь хамгийн багадаа хүснэгт 7,2,1-т заасан хэмжээтэй байна.
- 8.3. Нийтийн эзэмшлийн зам талбайг ашиглагчаас тээврийн хэрэгслийн төлбөр авах үйл ажиллагааг гэрээний үндсэн дээрх уг зогсоолыг эзэмшигч хариуцна.
- 8.4. Байгууллагын өмнөх нийтийн эзэмшлийн зогсоолын 30 хүртэлх хувийг тухайн байгууллагад түрээслүүлж, төлбөрийг 7 хоног, сар, улирал, жилээр тооцож урьдчилан замын санд төвлөрүүлсэн байна.
- 8.5. Нийслэл хотын нийтийн эзэмшилд хамаарах, тээврийн хэрэгслийн зогсоолоос орох орлогын Нийслэлийн замын санд төвлөрүүлэх хувь хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтооно. Нийслэлийн замын санд төвлөрсөн төлбөрийн орлогыг Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18,5 дах заалтын дагуу зарцуулна

Ес. Хариуцлага

- 9.1. Цагийн хэтрэлт: Хотын төвд 2 цагаас илүү хэтрүүлж тээврийн хэрэгслээ зогсоолд тавьсан бол 0,5 цаг тутамд төгрөгийн торгууль ноогдуулна.
- 9.2. Буруу зогсолт: Галын болон түргэн тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоолын талбай, мөн зориулалтын бус газарт тээврийн хэрэгслийг байрлуулсан тохиолдолд ... –с хүртэл төгрөгөөр торгууль ноогдуулна.
- 9.3. Журамлах: Тээврийн хэрэгсэл эзэмшигч нь 3 ба түүнээс илүү удаа зөрчил гаргасан бол тухайн тээврийн хэрэгслийг журмын хашаанд ... сар хүртэл хугацаанд тавьж, холбогдох төлбөрийг авна.

Арав. Бусад зүйлс

- 10.1. Энэхүү журамд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

